журмын 1 дүгээр хавсралт
Маягт № ТТ-1

# ТӨЛБӨРИЙН ХҮСЭЛТ № 100

2022 оны 8 сарын 5 өдөр

| | | |
|---|---|---|
| ...гын нэр: **Байгаль орчны газар** | *Дансны дугаар* | **12,500,000.00** |
| *...трийн дугаар:* **9006974** | **100020013001** | |
| ...агчийн нэр: **ПОРТ МАКС ХХК** | *Дансны дугаар* | |
| *...трийн дугаар:* **5478936** | **5175008719** | |
| *... авагчийн банк:* **ХААН банк** | Ангилал | |
| *... дүн үсгээр:* *... хоёр сая таван зуун мянган төгрөг 00 мөнгө* | | |
| ... утга: | 71406 - Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол | |
| *...циклийн үнэ* | 81701 - Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | |
| | 0000 - Төрийн сан | |
| | *210801-Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж* | 12,500,000.00 |

*... хуудас №: 100*

| | Үндэслэх бичиг баримтын нэр | Он сар, дугаар | Төрийн сангийн тэмдэглэгээ |
|---|---|---|---|
| | Гэрээ | 2022.08.04 №БОХ-09/2022 | |

...га

Дарга: ..................................... /Ш.Марат/

Нягтлан бодогч: ...................... /Х. Тилеухан/

Төрийн санд гүйлгээ хийсэн

...... оны .... сарын .... өдөр

тэмдэг, гарын үсэг

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 01/267

Өлгий

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.3, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалт, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2, 17.2.9, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.2, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай 2022 онд хамтран ажиллах гэрээний биелэлтийг хангах ажлын хүрээнд байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах 2000000 /хоёр сая/, 5 /тав/ байгаль хамгаалагчдыг мотоциклээр хангах 12500000 /арван хоёр сая таван зуун мянга/, нөхөрлөлүүдэд дэмжлэг үзүүлэх чадавхжуулах сургалт зохион байгуулах 3000000 /гурван сая/, байгууллагын веб сайт, цахим мэдээллийг шинэчлэх 500000 /таван зуун мянга, биотехникийн арга хэмжээ 8000000 /найман сая/, Алтанцөгц, Баяннуур, Ногооннуур сумдад тус бүр 1 /нэг/ булаг шандны эхийг хамгаалж, орчныг тохижуулах 9000000 /есөн сая/, Чигэртэй голын байгалийн цогцолборт газарт биотехникийн арга хэмжээ авах 2000000 /хоёр сая/, Монгол Алтайн нурууны тусгай хамгаалалттай газарт ойжуулалт хийх 3000000 /гурван сая/, гоёл чимэглэл, жимсний модны тарьц суулгацаар хангах 15000000 /арван таван сая/, Алтай Таванбогдын байгалийн цогцолборт газрын төлөвлөсөн маршрутын дагуу отоглох цэг байгуулах 12000000 /арван хоёр сая/, нийт 67000000 /жаран долоон сая/ төгрөгийг Байгаль хамгаалах сангаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Т.Фестиваль/-т зөвшөөрсүгэй.

2. Дээрх санхүүжилтийг зориулалтын дагуу зүй зохистой зарцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /Ш.Марат/-т болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс /Х.Анар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Д.БАУЫРЖАН

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 04 өдөр Дугаар А/24 Өлгий

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/267 тоот захирамж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын аймгийн Засаг даргатай 2022 онд байгуулсан хамтран ажиллах гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2022 оны төсөвт тусгагдсан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас байгаль хамгаалагчдыг мотоциклээр хангах "ПОРТ МАКС" ХХК-д 12500000 /арван хоёр сая таван зуун мянга/, Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн газрын трактор, усны цахилгаан насос, бороожуулагчаар хангах "ПГЖМ" ХХК-д 57500000 /тавин долоон сая таван зуун мянга/ төгрөгийг гэрээний дагуу олгохыг нягтлан бодогч /Х.Тилеухан/-д зөвшөөрсүгэй.

2. Дээрх арга хэмжээний ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг мэргэжилтэн /Х.Даут/, мэргэжилтэн /Б.Хасым/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА Ш. МАРАТ

# НЭХЭМЖЛЭХ № . . . . .

Нэхэмжлэгч:

Байгууллагын нэр: "Портмакс ХХК" Их Хурд Бооний төв

Хаяг: ЧД БЗД - Нарны зам Энхтайваны гүүрний урд "Их Хурд" төв

Утас. Факс: 99101522

Э_шуудан

Банкны нэр Хаан Банк

Банкны дансны дугаар 5175008719

Регистрийн №: 5478936

Төлөгч:

Байгууллагын нэр: Байгаль орчин аялал жуулчлал

Хаяг: Өлгий сум байгаль орчин аялал жуулчлал газар

Гэрээний №

Нэхэмжилсэн огноо 2022.08.04

Төлбөр хийх хугацаа

| № | Гүйлгээний утга | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|
| | Жуулчин "150" | 4 | 3125,000 | 12,500,000 |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | Дүн | |
| | | | НӨАТ | |
| | | | | |
| | | | Нийт дүн | 12,500,000 |

Мөнгөний дүн Арван хоёр сая таван зуун мянган төгрөг (үсгээр) болно.

Дарга ........ /

(Тамга) Хүлээн авсан ........ /

Нягтлан бодогч ........ /

ПОРТ МАКС ХХК САНХҮҮ ТТС8138 5478936 УЛААНБААТАР

ТЕРГҮҮЛЭХ МЭРГЭЖИЛТЭН

**БАТЛАВ:**

"ПОРТ МАКС" ХХК-НИЙ
ЗАХИРАЛ ................ Х.САРАНТУЯА
2022 оны 08 сарын 04

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГА ................ Ш.МАРАТ
2022 оны 8 сарын 4

# ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2022.08.04 № 801-09/2022 Өлгий хот

## Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Иргэний хуулийн 343 дугаар зүйл, "БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БОАЖГ", түүнийг төлөөлж дарга Ш.Марат /цаашид "Захиалагч" гэнэ/, нөгөө талаас ПОРТ МАКС" ХХК-НИЙ Т.Шынберген /цаашид "Гүйцэтгэгч" гэх/ нар дор дурдсан ажлыг гүйцэтгэхээр харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

## Хоёр. Ерөнхий зүйл

2022 онд БОАЖСайд Аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 12.5 сая төгрөгт багтаан Байгаль хамгаалагчдыг "Нүүдэлчин zonhshen" ZS150 маркийн 4 мотоциклээр хангах арга хэмжээг зохион байгуулах /цаашид "Гэрээт ажил" гэх/ ажлыг батлагдсан төсөв, төлөвлөгөөний хүрээнд, захиалагчаас тавьсан нөхцөл, шаардлагын дагуу хийж гүйцэтгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

## Гурав. Талуудын эрх, үүрэг

**3.1. Захиалагч талын эрх, үүрэг**

3.1.1. Захиалагч тал нь гэрээт ажилд тусгах техник хэрэгсэлтэй холбоотой санал, хүсэлтээ нэмэх эрхтэй.

3.1.2. Захиалагч тал нь гэрээт ажилд тусгасаны дагуу чанартай шинэ техник, хүлээн авах үүрэгтэй.

3.1.3. Захиалагч тал нь эрх шилжүүлсэн үйл ажиллагаануудад батлагдсан төсвийг тогтсон хугацаанд гүйцэтгэгч талд шилжүүлэх үүрэгтэй.

3.1.4. Захиалагч тал нь гэрээт ажлын гүйцэтгэлийг батлагдсан төлөвлөгөө, нөхцөл шаардлагад тулгуурлан, холбогдох хууль тогтоомжийг үндэслэн хүлээж авах үүрэгтэй.

**3.2. Гүйцэтгэгч талын эрх, үүрэг**

3.2.1. Гүйцэтгэгч тал нь гэрээт ажилд заасан "Нүүдэлчин zonhshen" ZS150 маркийн мотоциклийг нийлүүлэх үүрэгтэй.

3.2.2. Гүйцэтгэгч тал нь гэрээт ажлыг гүйцэтгэхтэй уялдан гарах аливаа асуудалд захиалагч талтай зөвшилцсөний үндсэн дээр бодлогын дэмжлэгээр хангагдах эрхтэй.

3.2.3. Гүйцэтгэгч тал нь гэрээт ажлыг тогтоосон хугацаанд, захиалагчаас тавьсан нөхцөл, шаардлагын дагуу, чанарын өндөр түвшинд гүйцэтгэх, захиалагч талаас тавьсан санал, хүсэлтийг тусгах үүрэгтэй.

## Дөрөв. Гэрээний хугацаа

4.1 Гэрээт ажлыг 2022 оны 08 дугаар сарын 03-ний өдрөөс 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулна.

4.2 Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж, гүйцэтгэгч талын ирүүлсэн мотоциклийг захиалагч талаас дүгнэн хүлээн авч, гэрээний төлборийг бүрэн барагдуулснаар дуусгавар болно.

## Тав. Гэрээт ажлын төлбөр

5.1 Гэрээт ажлыг гүйцэтгэхэд шаардагдах нийт 12.500.000 /Арван хоер сая таван зуун мянган / мянган төгрөгийг захиалагч тал бүрэн хариуцна.

5.2 Гэрээт ажлын төлбөр болох 100 хувь буюу 12.500.000 /арван хоер сая таван зуун мянган / төгрөгийг гэрээ байгуулагдсанаас хойш ажлын 7 хоногийн дотор гүйцэтгэгч талд шилжүүлэн хүлээж авна.

5.3. "Нүүдэлчин zonhshen" ZS150 маркийн мотоциклийн нэг бүрийн үнэ 3.125.000 төгрөг.

## Зургаа. Гэрээ цуцлах, маргаан шийдвэрлэх

6.1 Гэрээт ажлын явцад гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн тохиолдолд захиалагч гэрээг цуцлах эрхтэй.

6.2 Гэрээт ажил дуусахаас өмнө захиалагч гэрээгээ цуцалсан бол гэрээ цуцлахаас өмнө гүйцэтгэгчид орсон орлого, учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

6.3 Гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд харилцан зөвлөрлийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэж шаардлагатай тохиолдолд Монгол Улсын хуулийн хүрээнд иргэний журмаар шүүхээр шийдвэрлүүлнэ.

## Долоо. Бусад

7.1 Гэрээг 2 хувь үйлдэн талууд болон БОАЖГазрын архивд тус бүр нэг хувийг хадгална.

7.2 Гэрээнд 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛӨН: | ЗАХИАЛАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛӨН: |
|---|---|
| "ПОРТ МАКС" ХХК-НИЙ төлөөлөл.........Т.ШЫНБЕРГЕН. | БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН..........Х Даут |
| ХАЯГ:<br>Баян-Өлгий аймаг, Өлгий сум 6-р баг<br>Утас: 99418435<br>Регистерийн дугаар: 5478936<br>ХААН банк: 5175008719<br>"ПОРТ МАКС" ХХК | ХАЯГ:<br>Баян-Өлгий аймаг, Өлгий сум,<br>5-р баг<br>Утас:99423066, 85866767<br>Регистерийн дугаар: 9006974<br>Банк, дансны дугаар: 100020013001<br>Төрийн сан банк |

# БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022.08.02

Уг хурал 14 цаг 00 минутанд газрын даргын өрөөнд эхэлж, тус хуралд Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга Ш.Марат, Ахлах мэргэжилтэн С.Мандат Мэргэжилтэн М.Марина, И.Жулдыз, Б.Шеген, Х.Даут, Н.Болатхан нар оролцов. Хурлыг газрын дарга Ш.Марат даргалав.

Хэлэлцэх асуудал:

1. БОАЖСайд тус аймгийн Засаг даргатай 2022онд хамтран ажиллах гэрээнд тусгагдсан 4ширхэг мотоциклийг авч шаардлагатай байгаль хамгаалагчдад хүлээлгэж өгөх талаар
2. Говь-Сүмбэр аймагт зохион байгуулагдах "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний зорилтыг бүс, орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах нь" зөвлөгөөнд оролцох талаар
3. 2 албан хаагчийн өгсөн өргөдлийн талаар

Санал:

Газрын дарга Ш.Марат: Миний бодлоор энэ удаагийн 4 мотоциклийг байгаль хамгаалагч Жанарбек, Туяхбай, С.Бахытжан, Ерболат нарт өгөх саналтай байна.

Мэргэжилтэн М.Марина: Нэг мотоциклийг Толбо сумын байгаль хамгаалагч Сураганд өгөх нь зүйтэй. Учир нь Толбо сумд загас агнуурын болон хог хаягдлын ажил ихтэй.

Мэргэжилтэн Х.Даут: Толбо сумын ЗДТГ-аас надад өгсөн мотоциклийг байгаль хамгаалагч Сураганд өгөөгүй учраас нэг мотоциклийг тус сумын байгаль хамгаалагч сураганд өгөх нь зүйтэй.

Газрын дарга Ш.Марат: Говь-Сүмбэр аймагт зохион байгуулах зөвлөгөөнд хамт олноороо оролцох боломжгүй. Учир нь 2 талдаа 3800 гаруй км-т их хэмжээний зардал гарах юм. Тийм учраас 2 мэргэжилтэнийг оролцуулах хэрэгтэй байна. Өөрийн хүсэлтээр явах хүмүүс байвал хэлээрэй.

Газрын дарга Ш.Марат: 1жилийн чөлөө хүссэн М.Жанаргүлд болон 2жилийн чөлөө авахаар өргөдөл гаргасан байгаль хамгаалагч Бахытгүлийн оронд хүмүүс томилох хэрэгтэй байна. Бугат сумд байгаль хамгаалагчаар ажиллах Бахытгүлийн оронд чадварлаг эрэгтэй хүн авах хэрэгтэй. Тус сумд хайрга болон түлээний модны зөрчил их гардаг юм.

Ахлах мэргэжилтэн С.Мандат: Бичиг хэргийн ажилтан М.Жанаргүлийн оронд нэг хүн авах хэрэгтэй.

Мэргэжилтэн М.Марина: бичиг хэргийн ажилтан М.Жанаргүлийн оронд ажлын ачаалал даах чадвартай эрэгтэй хүн авах нь зөв.

Шийдвэрлэсэн нь

Сайдтай байгуулсан гэрээний дагуу 12.5 сая төгрөгийн гэрээ байгуулсан “ПОРТ МАКС” ХХКомпанид шилжүүлэхийг Ня-БО Х.Тилеуханд үүрэг болгов. Уг мотоциклийг Ногооннуур сумын байгаль хамгаалагч Х.Жанарбек, Цэнгэл сумын байгаль хамгаалагч С.Бахытжан, Баяннуур сумын байгаль хамгаалагч Ж.Ерболат, Толбо сумын байгаль хамгаалагч Х.Сураган нарт гардуулж өгөхийг хуралд оролцсон бүх албан хаагчид дэмжиж батлав.

Говь-Сүмбэр аймагт зохион байгуулах зөвлөгөөнд мэргэжилтэн Б.Шөген, өөрийн хүсэлтээр, байгаль хамгаалагч А.Дамысбек нарыг даргын саналаар явж оролцохоор болж шийдвэрлэв.

Өргөдөл гаргасан бичиг хэргийн ажилтан М.Жанаргүлийн оронд 1 жилээр компьютер, бичиг хэргийн мэдлэгтэй хүнийг, Байгаль хамгаалагч Бахытгүлийн оронд нөөцөд байгаа нэг хүнийг 2 жилийн хугацаатай томилж ажиллуулахаар тус тус шийдвэрлэсэн болно.

**Батлав:** БОАЖГазрын дарга: Ш.Марат

Хурлын тэмдэглэл хөдөлгөсөн мэргэжилтэн Н.Болатхан

## ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНИЙ ДҮГНЭЛТ

Дугаар № БОАЖГ-02

| | |
|---|---|
| Нийлүүлэгч | ПОРТ МАКС ХХК |
| Гэрээний дүн | 12.500.000 |
| Санхүүжүүлэх эх үүсвэр | Орон нутгийн төсөв |
| Ажлын нэр ба байршил | Өлгий сум |
| Төслийн менежер | Т.Шынберген |

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ

| НӨХЦӨЛ | ХЭРЭГЖИЛТ |
|---|---|
| 1.1 Захиалагч нь БОАЖСайд аймгийн засаг даргын 2022 онд хамтран ажиллах төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Байгаль хамгаалагчдыг Нүүдэлчин zonhsen ZS150 маркийн 4 мотоциклээр хангах ажлыг зохион байгуулах | Нийлүүлэгч уг барааг захиалагчид хүлээлгэн өгч, төлбөрийг гүйцэтгэлээр тооцож гэрээнд заасан хэлбэр, хугацаанд хийсэн. |
| 1.2 Худалдагч худалдан авч байгууллагаас тавих чанарын шаардлагын бүрэн хангасан байна. | Худалдагч худалдан авч байгууллагаас тавих чанарын шаардлагын бүрэн хангаж ажилласан. |
| 1.3 Энэхүү гэрээнд заасан үйл ажиллагаа явуулахад МУ-ын Иргэний хууль болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, бусад хууль тогоомжийн дагуу олон нийтийн оролцоотойгоор бараа, ажил үйлчилгээ худалдан авахтай холбогдсон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагын тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино. удирдлага болгоно. | Нөхцөл байдал үүсээгүй |
| 1.4 БОАЖСайд аймгийн Засаг даргын 2022 оны гэрээнд 12.5 сая төгрөг буюу 5 мотоцикл гэж тусгагдсан. | Уг гэрээнд 5 мотоцикл гэж тусгагдсан боловч тухайн үеийн “Нүүдэлчин zonhsen” ZS150 мотоциклийн зах зээлийн нэг бүрийн 3.125.000 байв. |

### ХОЁР. ХУДАЛДАН АВАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

| НӨХЦӨЛ | ХЭРЭГЖИЛТ |
|---|---|
| 2.1. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүрэг болох БОАЖГазраас өгсөн техникийн нөхцөлийн дагуу уг ажлыг /бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, зөвлөх үйлчилгээ/-г 2022 оны 08-р сарын 03-аас 2022 оны 08 дугаар сарын 10-ний өдрийн дотор гүйцэтгэнэ. | Худалдан авагч нь бараа нийлүүлэгчийн нийт зардлын 100%-ийг нэхэмжлэлийн дагуу шилжүүлсэн. |
| 5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно. | Нөхцөл байдал үүсээгүй |

| | |
|---|---|
| 5.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл:<br>5.2 Бусад шаардлагатай баримт бичиг:<br>5.3 Гүйцэтгэгчийн ирүүлсэн санал:<br>5.4. Гэрээний тусгай нөхцөл:<br>5.5. Гэрээний ерөнхий нөхцөл:<br>5.6. Ажлын зураг, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт:<br>5.7. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үнэ бүхий үйл ажиллагааны хуваарь:<br>5.8. Санхүүгийн хуваарь:<br>Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хооронд зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ. | |
| 2.3. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл заасан эрх, үүрэг хүлээнэ. | Нөхцөл байдал үүсээгүй |
| 2.4. Гүйцэтгэгч нь энхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдолын гарсан даруй арилгах үүрэг хүлээнэ. | Нөхцөл байдал үүсээгүй |

## ДӨРӨВ. ГЭРЭЭТ АЖЛЫН ХӨЛС, ТӨЛБӨР ХИЙХ НӨХЦӨЛ

| НӨХЦӨЛ | ХЭРЭГЖИЛТ |
|---|---|
| 4.1. Байгаль хамгаалагчидад унаа худалдан авах ажлын явцад гарах ажиллах хүчний зардал, НӨАТ, тээврийн зардал зэрэг бүрэн багтсан тул захиалагч нь нэмэлтээр ямар нэг төлбөр төлөхгүй. | Нөхцөл байдал үүсээгүй |
| 4.2. Барааг хүлээн авсан актыг үндэслэн төлбөрийн үлдсэн хувийг Хөх сэрхийн нурууны УТХГ-ын дансанд шилжүүлнэ. | Нөхцөл байдал үүсээгүй |
| 4.3. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх гүйцэтгэсэн ажил болон зөрчил, гологдол гарсан даруй арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хүлээнэ. | Нөхцөл байдал үүсээгүй |

## ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮЙЛЧЛЭХ ХУГАЦАА

| НӨХЦӨЛ | ХЭРЭГЖИЛТ |
|---|---|
| 5.1 Гэрээний үйлчлэх хугацаа гэрээ байгуулсан өдрөөс буюу 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн 2022 оны 08 дугаар сарын 10-ний дотор гүйцэтгэхээр энхүү гэрээг байгуулав. | Нөхцөл байдал үүсээгүй |
| 5.2. Гэрээний үйлчлэх хугацааг нэг талын бичгээр гаргасан хүсэлт, нөгөө талын | Нөхцөл байдал үүсээгүй |

| | |
|---|---|
| зөвшөөрлөөр сунгаж болно. | |
| 5.3. Талууд гэрээг гэрээний хугацааг нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн хийж дуусгаж, акт үйлдсэнээр гэрээ дуусгавар болно. | Нөхцөл байдал үүсээгүй |
| 5.4. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана. | Нөхцөл байдал үүсээгүй |

ЗУРГАА. ХАРИЦЛАГА

| НӨХЦӨЛ | ХЭРЭГЖИЛТ |
|---|---|
| 6.1. Бараа нийлүүлэгч барааг гэрээний хугацаанд нь гүйцэтгээгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй бараа, үйлчилгээний үнийн дүнгийн 0,05 хувиар алданги тооцно. | Нөхцөл байдал үүсээгүй |
| 6.2. Талуудын буруутай үйл ажиллагааны улмаас учирсан биет хохирлыг талууд өөрсдийн зардлаар бүрэн харицан барагдуулна. | Нөхцөл байдал үүсээгүй |

ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

| НӨХЦӨЛ | ХЭРЭГЖИЛТ |
|---|---|
| 7.1. Гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ. | Нөхцөл байдал үүсээгүй |
| 7.2. Талууд тохиролцоонд хүрч чадаагүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шүүхэд тавьж шийдвэрлүүлнэ. | Нөхцөл байдал үүсээгүй |

ГЭРЭЭГ ДҮГНЭСЭН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
мэргэжилтэн Х.Даут

*/гарын үсэг, тамга/*
*Захиалагчийн хаяг:*
*Баян- өлгий аймгийн*
*Өлгий сум 5-р баг*
*Утас: 70422667,85866767*

ГҮЙЦЭТГЭГЧ ТӨЛӨӨЛЖ:
ПОРТ МАКС ХХК-ний МЕНЕЖЕР:
Т. ШЫНБЕРГЕН

*/гарын үсэг, тамга*
*гүйцэтгэгчийн хаяг:*
*Баян- өлгий аймгийн*
*Өлгий сум 9-р баг*
*Утас:*99418435